

"ЭРҮҮЛ МЭНД-ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАЙРЛАЯ" УРИАТАЙ

СПОРТ ЯВГАН АЯЛЛЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

1.1. Хуульчдын эрүүл мэнд, бие бялдрыг чийрэгжүүлэх, тэдэнд амьдралын зөв дадал, хэвшил олгох, хоорондоо танилцаж туршлага солилцох, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалахад энэхүү тэмцээний зорилго оршино.

Хоёр. Тэмцээний удирдлага, зохион байгуулалт

2.1. Тэмцээний үндсэн удирдлага зохион байгуулалтыг Монголын Хуульчдын Холбоо (цаашид "холбоо" гэх)-ны Тамгын газар, холбооны Байгаль орчны эрх зүйн дэд хороо, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар хариуцан энэхүү удирдамжид заасан чиг үүргийн хүрээнд зохион байгуулна.

Гурав. Тэмцээний явагдах хугацаа, оролцогчид

3.1. Тэмцээн 2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Улаанбаатар-Баянзүрх хайрхан-Хар усан тохой гэсэн маршрутаар (авто машинаар 15 км болон явган алхалтаар 10 км орчим) аялах байдлаар зохион байгуулна.

3.2. Тэмцээнд холбооны чиг үүргийн болон сайн дурын хороод, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатын шүүхийн Тамгын газраас тус бүрээс нэг баг оролцох бөгөөд баг тус бүр эрэгтэй 5, эмэгтэй 5 гэсэн нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй байна, мөн 1 дасгалжуулагчтай байж болно.

3.3. Хоёр баг бүрдүүлэн оролцож болно.

3.4. Чиг үүргийн хоёр хороо хамтран оролцож болно.

3.5. Багийн бүрэлдэхүүнд тамирчид, дасгалжуулагчид, хөгжөөн дэмжигчид хамаарна.

Дөрөв. Тэмцээнд оролцогчид тавигдах шаардлага

4.1. Тэмцээнд оролцогч нь тухайн хорооны гишүүнчлэлтэй, тухайн байгууллагын ажилтан байна.

4.2. Багийн гишүүн бүр өөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хариуцах бөгөөд явган аяллын талаар дасгалжуулагчаас зөвлөгөө өгнө.

4.3. Аяллын турш оролцогчид тухай өдрийн цаг агаарт тохирсон хувцас өмсөх, эрүүл мэнд болон өөрийн аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

4.4. Оролцогчид аяллын хөтөч буюу тэмцээний Ерөнхий шүүгчийн удирдлага, зааврыг тухай бүр даган биелүүлэх үүрэгтэй.

4.5. Аяллын явцад согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хатуу хориглоно.

4.6. Оролцогчид аяллын явцад зөвшөөрөлгүй гал гаргах, зөвшөөрөгдөөгүй газарт бие засах, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх аливаа үйлдэл гаргахгүй байх үүрэгтэй.

4.7. Тэмцээнд оролцогч нь дараах хувийн бэлтгэлийг хангана. Үүнд:

- ✓ үүргэвч солих ээлжийн хувцас (фодволк, цамц, өмд, цув, оймс, гутал, таяг ... гэх мэт);
- ✓ нэг өдрийн хүнс (шингэн уух зүйл, хоол хүнс, идэх юм);
- ✓ Аяга, халбага;
- ✓ борооны цув;
- ✓ Гар чийдэн
- ✓ Эмийн сан
- ✓ Чүдэнз

4.8. Тэмцээнд оролцогч баг тус бүр нь дараах бэлтгэлийг хангана. Үүнд:

- ✓ баг бүр өөрийн салбарын онцлогийг илэрхийлсэн хаяг, эмблем, лого, жигд хувцастай байх;
- ✓ багийн эмийн сангийн бүрдэл (өвчин намдаах, даралтын эм, ходоод, гэдэсний эм);
- ✓ олс (аяллын зориулалттай);
- ✓ Хүрз;
- ✓ Баг бүр тогоо шанага, гал тогоогоо бэлдэж ирж цай чанах, хоол, хүнсээ хийж идэх боломжтой.

Тав. Тэмцээн явуулах журам

5.1. Тэмцээнийг дараах ангиллаар зохион байгуулна. Үүнд:

- 5.1.1. аялал;
- 5.1.2. алхалт;
- 5.1.3. буухиа тэмцээн.

5.2. Тэмцээнийг дүгнэх үзүүлэлтүүд:

- тэмцээний нээлт, хаалтын ажиллагааны ирц;
- аяллын явц, цуваанд яваа багийн сахилга, зохион байгуулалт;
- багийн болон хувийн бэлтгэл;
- галын болон отгийн ариун цэвэр, эко байдал;
- багийн эмийн сангийн бүрдэл;
- багийн аяллын тэмдэглэл хөтлөлт;
- бэлэг солилцох.

Зургаа. Мэдүүлэг хүлээн авах хугацаа, техникийн зөвлөгөөн

6.1. Тэмцээний мэдүүлгийг 2024.09.16-ны өдрийн 15:00 цаг хүртэл батлагдсан загварын дагуу хороо хариуцсан мэргэжилтнээрээ дамжуулан холбооны Байгаль орчны эрх зүйн дэд хорооны зохицуулагч Р.Лхагвабаярт /цаасан болон цахим хэлбэр (Google form)-ээр өгч нэгтгүүлнэ.

6.2. Техникийн зөвлөгөөнийг 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 15:00 цагт Хуульчдын холбооны 3 давхарт байрлах Хуульчдын танхимд зохион байгуулна.

6.3. Техникийн зөвлөгөөнд багийн ахлагч, дасгалжуулагч, хороо хариуцсан мэргэжилтнүүд оролцоно.

Долоо. Дүгнэх журам, шагнал

7.1. Гурван спорт тэмцээний нийлбэр оноо болон энэхүү удирдамжийн 5.2-т заасан дүгнэх үзүүлэлтийг харгалзан амжилтаар эхний гурван байрыг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж, урамшуулна.

7.2. Тэмцээний удирдамж болон зохион байгуулалтай холбоотой аливаа асуудлыг Ажлын хэсэг эцэслэн шийдвэрлэж болно.

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ТАМГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРХ ЗҮЙН ДЭД ХОРОО